



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2017 оны 1 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот

Бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

1. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн байгуулсугай:

- | | |
|---------|---|
| Ахлагч | -Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Гишүүд: | -Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга;
-Үндэсний хөгжлийн газрын дарга;
-Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга;
-Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
-Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга;
-Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн;
-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн;
-Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын харилцаа, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагааны зохицуулалтын хэлтсийн дарга;
-Иргэний нисэхийн ерөнхий газрын Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны ахлах эдийн засагч;
-“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ |


буудал барих төсөл"-ийн захирал;

-Монголын агаарын тээвэрлэгчдийн холбооны тэргүүн
(тохиролцоноор).

Нарийн бичгийн
дарга

-Зам, тээврийн хөгжлийн яамны Агаарын тээврийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" Ерөнхий сайдын 2016 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 63 дугаар захирамжийн 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Зам, тээврийн хөгжлийн сайд

Д.ГАНБАТ